

ТӨРИЙН АУДИТ



**Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны
эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан**

2017.06.30

Гарчиг

Товчилсон үгийн тайлбар.....	3
Удирдлага зохион байгуулалт.....	4
Санхүүгийн тайлангийн аудитын талаар.....	4
Гүйцэтгэлийн аудитын талаар.....	7
Нийцлийн аудитын талаар.....	9
ИТХ болон өөрсдийн санаачлагаар хийсэн аудитын талаар.....	10
Дотоод ажлын талаар.....	12
Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар.....	13
Дүгнэлт, санал.....	13

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжлийн сан
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр

Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалт:

МУ-ын УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан ҮАГ-ын 2017 онд хийх аудитын төлөвлөгөө, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2015-2018 оны стратеги төлөвлөгөө, 2017 онд дэвшүүлсэн “**САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ**” жилийн зорилтын хүрээнд Аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын 2017 оны 01 тоот тушаалаар баталсан төлөвлөгөөнд тусгагдсан 39 ажил үйлчилгээг 7 багцад хуваан хийхээр санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын 3 багийн зохион байгуулалтаар ажиллалаа.

Дорнод аймгийн Аудитын газар нь 2017 оны 2 дугаар улирлын байдлаар санхүүгийн тайлангийн аудитаар 92 байгууллагын тайлан баталгаажуулан санал дүгнэлтийг өгч, гүйцэтгэлийн 2, нийцлийн 1 аудитыг тус тус гүйцэтгэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэл хийх нийцлийн аудитыг эхлүүлээд байна.

Аудитаар 163 ширхэг 7,8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлэн аудитын явцад 2,4 тэрбум төгрөг буюу 31,3 хувийг залруулж ажилласан.

Нийт зөрчлийн 74,7 сая төгрөг орлого бүрдүүлэлттэй, 312,3 сая төгрөг төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй, 3,6 тэрбум төгрөг нягтлан бодох бүртгэл, тайлагналттай, 1,4 тэрбум төгрөг арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой, 2,0 тэрбум төгрөг нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 180,6 сая төгрөг нь дотоод хяналттай, 184,0 сая төгрөг нь бусад асуудлаар өгсөн зөрчил эзлэж байна.

Тайлант хугацаанд 114 зөвлөмж өгснийг 71,9 хувь хэрэгжүүлэн биелэлтийг холбогдох байгууллагуудаар гаргуулан аваад байна.

Тайлант хугацаанд 54,6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах 42 албан шаардлага өгч, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар хариуцсан аудитор, шинжээч нарт үүрэг даалгавар өгсний дагуу өмнөх оны 25,3 сая төгрөгийн, тайлант хугацааны 9,1 сая төгрөгийн актыг барагдуулан, 2,4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулж, 34,4 сая төгрөгийн төлбөрийн актны, 2,1 сая төгрөгийн баталгаажуулалтын орлогыг тус тус улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Аудитаар 10 ширхэг 54,6 сая төгрөгийн санхүүгийн, 9 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэн харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн 85,0 сая төгрөгийн өртөг, 24'920 хүн/цаг зарцуулсан ажилласан.

Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн аудит:

Орон нутаг дахь 222 байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулахаас 20 байгууллагад итгэл үзүүлэн, 110 байгууллагыг түүвэрт хамруулан, 92 байгууллагын тайланг баталгаажуулан, санхүүгийн тайлангийн аудитын СТАУС програмд оруулж нийт 27,1 сая төгрөгийн өртөг, 5312 хүн/цаг зарцуулан ажиллалаа. Үүнд: Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14, шууд захирагчийн 71, орон нутгийн болон төрийн өмчит үйлдвэрийн газруудын 6 тайлан хамрагдсан.

Аудитад хамрагдсан 89 байгууллагад зөрчилгүй, Дорнод бүсийн сургалт эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн хүрээлэн ТӨҮГ-т сөрөг, Хөлөнбуйр сумын ЗДТГ, Цөм сүргийн төв ТӨҮГ-т хязгаарлалтай санал дүгнэлт өгч ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 9,9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3,8 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах 37 албан шаардлага өгч, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар хариуцсан аудитор, шинжээч нарт үүрэг даалгавар өгсний дагуу өмнөх оны 10,5 сая төгрөгийн, тайлант хугацааны 9,1 сая төгрөгийн актыг барагдуулан, 2,4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулж, 19,6 сая төгрөгийн төлбөрийн актны 2,1 сая төгрөгийн баталгаажуулалтын орлогыг тус тус улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн 6 ширхэг 9,9 сая төгрөгийн санхүүгийн, 6 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэн харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн ажилласан.

2.1. Санхүүгийн тайлан баталгаажуулалтын талаар товч дурьдвал:

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт зөрчлийн 74,7 сая төгрөг нь орлого бүрдүүлэлттэй, 3,2 тэрбум төгрөг нь бүртгэл, тайлагналттай, 15,0 сая төгрөг нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй, 1,5 тэрбум төгрөг нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 65,5 сая төгрөг нь дотоод хяналттай, 19,6 сая төгрөг нь бусад асуудалтай холбоотой байна.

Илэрсэн зөрчлийн 9,9 сая төгрөгт 6 ширхэг төлбөрийн акт тогтоон, 3,8 тэрбум төгрөгийн зөрчилд 37 албан шаардлага хүргүүлсэн.

Мөн Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа гаргаж Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй 35 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн.

Орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн оролцоотой байгууллагууд нь хязгаарлалттай болон сөрөг санал дүгнэлт авч байгаа, төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн алдаа зөрчлийн ихэнх хувийг бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал эзэлж байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Нягтлан бодогч нар хуульд заасан үүргээ хэрэгжүүлж, удирдлагыг санхүүгийн мэдээллээр бүрэн хангаагүй.
- Бүтэц орон тооны өөрчлөлт, шинэ томилгоо.
- Удирдах ажилтны хуулийн мэдлэг дутмаг
- Дотоод хяналт хангалтгүй ажилласан.
- Хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэх, санаатай үйлдэл гаргах зэрэг алдаа зөрчил байна.

2.2. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлангийн талаар товч дурьдвал:

Аймгийн нийт төсвийн орлогын төлөвлөгөө 55,9 тэрбум төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэл 55,3 тэрбум төгрөг гарч үүнээс тусламжийн орлого буюу санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн орлого 38,2 тэрбум төгрөгийг хасаж тооцоход аймгийн төсвийн нийт орлого 17,1 тэрбум төгрөг байна.

Аймгийн 2016 оны нийт орлогын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 3,8 тэрбум төгрөгөөр буюу 7,3 хувиар өссөн байгаа бөгөөд татварын орлого 20,4 хувиар өсөж, татварын бус орлого 83,3 хувиар, тусламжийн орлого 1,5 хувиар өссөн байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 3,8 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн санд 4,1 тэрбум төгрөг олгосон байна.

Төсвийн эх үүсвэрийн 70 хувь буюу 38,2 тэрбум төгрөг нь тусламжийн орлого буюу санхүүгийн дэмжлэгээс, 30 хувь буюу 17,1 тэрбум төгрөг нь орон нутгийн татварын орлогоос бүрдсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 15,4 тэрбум төгрөг, гүйцэтгэл 17,1 тэрбум төгрөг бөгөөд 10,6 хувиар буюу 1,6 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Дорнод аймгийн 2016 оны орон нутгийн төсвийн нийт зарлагыг 55,9 тэрбум төгрөгөөр төлөвлөн баталснаас 54,5 тэрбум төгрөг буюу 97,4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсөвт байгууллагуудын зардалд 24,3 тэрбум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн зардалд 29,2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн санхүүгийн тайлангаар авлагын эхний үлдэгдэл 4,4 тэрбум төгрөг байснаас оны эцэст 4,3 тэрбум төгрөг болж 156,2 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт 4,3 тэрбум төгрөгийн авлагын хувь хүнээс авах авлага 3,0 тэрбум төгрөг, байгууллагаас авах авлага 1,0 тэрбум төгрөг, Ажилчидтай холбоотой авлага 11,0 сая төгрөг, бусад авлага 262,9 сая төгрөг байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд тусгагдсан авлагын дүн оны эхний үлдэгдэлтэй харьцуулахад 156,2 мянган төгрөгөөр буурсны дотор орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын авлага 209,0 мянган төгрөг буюу 48,8 хувиар буурсан байна.

Хувь хүнээс авах авлага өндөр байгаа нь Сум хөгжүүлэх сангаар аж ахуй нэгж, иргэдэд олгосон зээлтэйгээр холбогдон үүссэн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн санхүүгийн тайлангаар өр төлбөрийн эхний үлдэгдэл 4,9 тэрбум төгрөг байснаас оны эцэст 3,8 тэрбум төгрөг болж 1,1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийт 3,8 тэрбум төгрөгийн өр төлбөрийн байгууллагад өгөх өглөг 241,4 сая төгрөг, хувь хүмүүст өгөх өглөг 121,4 сая төгрөг, ажиллагсадтай холбогдсон өглөг 20,7 сая төгрөг, хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг 3,4 тэрбум төгрөг, бусад өглөг 6,4 сая төгрөг байна.

Нийт өр төлбөр өмнөх оноос 1,1 тэрбум төгрөгөөр буурсан. Орон нутгийн байгууллагын өрийн 90,1 хувийг Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өглөг эзэлж байгаа бөгөөд түүний 85,6 хувь буюу 3,3 тэрбум төгрөг нь Дорнод НАА ХХК-ийн Азийн хөгжлийн банк, МУ-ын ЗГ, АЗДТГ-ын гурвалсан гэрээгээр орон нутгийн Хотуудын Нийтийн аж ахуйг хөгжүүлэх МОН1907 төслөөр олгогдсон зээл эзэлж байна.

Төсвийн тухай хуулийн “Төсвийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, батлах” тухай 5 дугаар бүлгийн 27.5-д “Орон нутгийн төсвийн төсөл бэлтгэх нарийвчилсан зааврыг төсвийн удирдамжид тусган аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ” гэж заасан. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2.1.4-д “Төсвийн төсөл боловсруулахад төсвийн удирдамжийг баримтлах” гэж заасан.

Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох Сангийн Яамнаас Дорнод аймгийн Засаг даргад ирүүлсэн төсвийн удирдамжид аймгийн ИТХ-ын орон тоог 7, ЗДТГ-ын орон тоог 63 байхаар тусгажээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн барьсан 2016 оны орон нутгийн төсвийн төсөлд АИТХ-г 13, АЗДТГ-г 76 орон тоотой байхаар өргөн мэдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т заасан төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад баримтлах “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” зарчим, 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Энэ нь АИТХ, АЗДТГ-ын Дорнод аймаг дахь Төрийн аудитын газраас 2016, 2017 онуудын төсвийн төсөлд бууруулах санал өгсөн боловч хэвээр батлан Төсвийн тухай хууль болон Сангийн Яамнаас өгсөн чиглэлийг баримтлан ажиллаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд нэмэлт төсвийг төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн бүрэлдэхүүн хэсэг байхаар заасны дагуу төсөвт байгууллагуудад нэмэлт санхүүжилтийн данс нээгдсэн бөгөөд 2016 онд 2,1 тэрбум төгрөгийн орлого орж, 2,1 тэрбум төгрөгийн зарлага гарсан байна.

Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч нь 2006 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна. Уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2011 онд хүчингүй болсон Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийг үндэслэсэн байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасны дагуу НББ-ийн бодлогын баримт бичгийг хууль, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн шинээр боловсруулаж, баримтлан ажиллах албан шаардлага өгсөн.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 77,0 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 154,1 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,6 тэрбум төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 219,4 сая төгрөг, төсвийн урамшуулал 1,3 сая төгрөг нийт 2,1 тэрбум төгрөгийн орлого орсон байна.

Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудит:

Гүйцэтгэлийн 2 аудитыг хийж гүйцэтгэн аймгийн ТЕЗ, ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумдын ТЕЗ, ЗДТГ-ыг хамруулан гүйцэтгэн 13,5 сая төгрөгийн өртөг, 6048 хүн/цаг өдөр зарцуулан ажилласан.

Гүйцэтгэлийн аудитаар 6,1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах 4 албан шаардлага өгч, төлбөрийн акт, албан

шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар хариуцсан аудитор, шинжээч нарт үүрэг даалгавар өгсний дагуу өмнөх оны 1,1 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулан, 1,3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулж, 1,1 сая төгрөгийн төлбөрийн актыг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн 1 ширхэг 6,1 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэн харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн ажилласан.

3.1. “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-д хийсэн аудитын талаар товч дурьдвал:

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд Дорнод аймагт эрх шилжсэн 7.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээнд 1.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд нийт 1.4 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс 33.3 хувь буюу 465.2 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ өмнөх оноос шилжин ирж, 66.7 хувь буюу 932.0 сая төгрөгийн 32 төсөл, арга хэмжээг шинээр, нийт 48 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

Аудитаар нийт 1,3 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 1,2 тэрбум төгрөгийн 2 албан шаардлага бичиж, 8 зөвлөмж өгч нийт 9 сумдын хөрөнгө оруулалтын ажлыг газар дээр нь үзэж шалгахад илэрсэн гол зөрчлүүдийг дурьдвал:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд гарч байгаа зөрчил, дутагдал жил бүр давтагдаж, ТЭЗҮ, зураг төсөв нь хийгдээгүй хөрөнгө оруулалтын ажлууд батлагдсан.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хөгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн хөгжлийн цогц бодлого /2009-2021/, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилтод тусгагдаагүй ажлуудыг батлах асуудал хэвээр байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ТЭЗҮ, зураг төсөв, хуулийн шаардлага хангаагүй ажлуудыг баталж байна. Хэрлэн сумын 4-р багийн шинэ цэцэрлэгийн дэд бүтэц татах, Халхгол сумын Ялалт багийн цагдаагийн хэсгийн байр барих ажлууд хасагдсан байна. Энэ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудыг урьдчилсан тооцоо судалгаа, техник, эдийн засгийн үр ашиг, зураг төсвийг хийлгүйгээр төлөвлөж байгаа нь аймгийн ИТХ-аар дэмжигдэхгүй байх, хэрэгцээтэй ажлууд хөрөнгө оруулалтын жагсаалтаас хасагдах, нийгэмд хэрэгцээтэй төсөл, арга хэмжээнүүд хэрэгжихгүй байх эрсдэлүүд үүсэж байна.
- Төрийн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 4 төсөл арга хэмжээ дутуу буюу эхлээгүй.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 4, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээ үр ашиггүй, шаардлага хангахгүй.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хийгдсэн 1 төсөл, арга хэмжээг одоо болтол улсын комисс хүлээж аваагүй байсан.



Аудитын тайлангийн төслийн хэлэлцүүлгийг аймгийн Засаг дарга, түүний орлогч, зөвлөх болон холбогдох байгууллагуудын удирдлагууд оролцуулан хийн. тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор М.Давааням, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хугацаанд нь хүргүүлсэн.

3.2. Засгийн газраас олгосон векселийн үр дүн”

Манай аймагт 2016 онд Засгийн газрын векселээр санхүүжүүлсэн, эрх нь шилжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний ажил хийгдээгүй байна.

Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудит:

Нийцлийн аудитаар 38,6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 365,8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өгч, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар хариуцсан аудитор, шинжээч нарт үүрэг даалгавар өгсний дагуу өмнөх оны 13,7 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулан, 365,8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 13,7 сая төгрөгийн төлбөрийн актыг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн 3 ширхэг 38,6 сая төгрөгийн санхүүгийн, 3 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэн харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн 16'200 сая төгрөгийн өртөг, 1760 хүн/цаг өдөр зарцуулан ажиллалаа

4.1. “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”-д хийсэн аудитын талаар товч дурьдвал:

Аудитаар ОНХНС, аймаг, сумын ИТХ, Засаг дарга, ЗДТГ, СТСХ, ХОХБТХ, Багийн Засаг дарга, ИНХ-ыг хамруулж, ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилт, тайлагнал, хяналт зэргийг авч үзсэн.

Монгол Улсын “2016 оны төсвийн тухай” хуульд ОНХНС-гаас Дорнод аймагт олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 5,0 тэрбум төгрөгөөр баталсныг “Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-аар 4,1 тэрбум төгрөг болгон өөрчилсөн байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд 225 төрлийн 5,1 тэрбум төгрөгийн өртөгтэй төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр тодотгож төлөвлөсөн байна.

Аудитаар нийт 963,8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 38,6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 365,3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 559,4 сая төгрөгийн 8 зөвлөмж өгч, 13 сумдын хөрөнгө оруулалтын ажлыг газар дээр нь үзэж шалгалаа. Аудитаар илэрсэн гол зөрчлүүдийг дурьдвал:

- ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгийг хуульд заасны дагуу хуваарилаагүй байна.
- Төсвийн тухай хуульд нийцэхгүй хөтөлбөр, урсгал зардалд 33,9 сая төгрөгийг баталж санхүүжүүлсэн байна.
- ТЭЗҮ-гүй 300,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 хөрөнгө оруулалтыг аймгийн ОНХС-гаар хийхээр баталсан.
- 144,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтын аргыг буруу сонгосон.
- Нийт 8 хөтөлбөрт 38,6 сая төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэн.
- ГХБХБГ болон МХГ-ууд нь захиалагчийн хяналтыг тавьж ажилласан байна.
- Аймгийн ОНХС-гаар хийгдсэн 355,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг эзэмшигч тодорхойгүйгээс бүртгэлд тусгаагүй байна.
- Аймаг сумын ИТХ болон эрх бүхий байгууллагууд хяналт тавьж ажиллаагүй, дүн шинжилгээ хийгээгүй байна.

Аудитын тайлангийн хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд хийж хэлэлцүүлэгт дарга, Тэргүүлэх аудитор, нийцлийн аудитын баг болон аймгийн Засаг дарга, түүний орлогч, зөвлөх болон холбогдох байгууллагуудын удирдлагууд оролцлоо.

Тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Алтанзул, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хугацаанд нь хүргүүлсэн.

4.2. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын гүйцэтгэл”-д хийсэн аудитын талаар товч дурьдвал:

Нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн ухуулах байр, шатар туслагч, ухуулагчдын тоон мэдээг УАГ-ын НАГ-т хүргүүлээд байна.

Тавдугаар бүлэг. ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хийсэн аудит:

ИТХ-ын захилгаар хийсэн аудитаар 6,1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 38,0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага өгч, 1 ширхэг 6,1 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэн харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн 13,5 сая төгрөгийн өртөг, 3240 хүн/цаг өдөр зарцуулан ажиллалаа

5.1. “Сум хөгжлийн сангийн зарцуулалт”-д хийсэн аудитын талаар товч дурьдвал:

Аудитад төсвийн Ерөнхийлөн захирагч, сумдын ИТХ, Засаг дарга, сумдын санхүү албаны дарга, мэргэжилтэн, ЖДҮ-ийн мэргэжилтэн, эрх бүхий холбогдох албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгжүүдийг хамруулан тэдгээрийн 2014-2016 онуудын

ажлын тайлан, статистик мэдээ, судалгаа, бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэсэн.

Сумдын “сум хөгжүүлэх сан”-гууд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 3,2 тэрбум төгрөгийн авлага тайлагнасан бөгөөд үүнээс хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлага 1,4 тэрбум төгрөг байна.

Аудитын явцад нийт 13 сумдаар газар дээр нь ажиллаж СХС-гийн зээлдэгчид болон дараа дараагийн зээл хүсэгч иргэдтэй уулзаж сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэснээр нийт 205,7 сая төгрөгийг барагдуулан ажиллан тайлангийн төслийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээд байна.

Аудитын үр дүнгийн талаарх хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд дарга, Тэргүүлэх аудитор, нийцлийн аудитын багийн гишүүд болон аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, сумдын Засаг дарга нарыг оролцуулан хийхээр төлөвлөж байна.

5.2. “ДБЭХС” ТӨХК-ийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын талаар товч дурьдвал:

Газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөр, аймгийн ИТХ-ын захиалгын дагуу “ДБЭХС” ТӨХК-ийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 595,6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 38,0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 6,1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тавигдаж, 551,5 сая төгрөгийн зөрчилд 16 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар илэрсэн гол зөрчлүүдийг дурьдвал:

- 2016 оны зорилтот түвшин биелсэн ч үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн бүтээмж, чанарын удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.
- Ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлахдаа ил тод, нээлттэй зарлахгүй, ажилтан, удирдах ажилтан сонгон шалгаруулж авахдаа “Боловсон хүчний нөөцийг судалж бүрдүүлэх, ажилд авах хүнийг сонгон шалгаруулах журам”, ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг мөрдөхгүй байна. Мэргэжлийн бус, мэргэжил эзэмшээгүй иргэдийг ажиллуулсан.
- Ажлын байрны тодорхойлолт нь агуулга, бүтцийн хувьд стандартад нийцээгүй, “Боловсон хүчний нөөцийг судалж бүрдүүлэх, ажилд авах хүнийг сонгон шалгаруулах журам”-ын 3.3-ын “б” дахь заалт нь утга агуулгын хувьд алдаатай.
- Эрчим хүчний салбар болон бусад салбарт хандив, урамшуулалд 6,1 сая төгрөгийг зарцуулсан.
- Авлага 1087,0 хувиар зорилтот түвшнээс өссөн.
- Үйл ажиллагааны нийт зардал 5,7 тэрбум төгрөгөөр хэтэрсэн.
- Төлөвлөгөөнд тусгагдаагүй 321,7 сая төгрөгийн 16 бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан.
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шаардлага хангаагүй ажилтанг худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад оруулан ажиллуулсан.

- Худалдах, худалдан авах гэрээнд заагдсан хугацааг хэтрүүлсэн ажилд 2016 онд алдангийг суутган тооцоогүй нийт 38,0 сая төгрөгийн 7 ажил.

Аудитын тайлангийн хэлэлцүүлгийг “ДБЭХС”ТӨХК-ийн сургалтын танхимд хийж хэлэлцүүлэгт газрын дарга, Тэргүүлэх аудитор, гүйцэтгэлийн аудитын алба болон ДБЭХС ТӨХК-ийн удирдлагуудыг оролцуулан хийж тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ болон “ДБЭХС” ТӨХК-д хүргүүлсэн.

Зургадугаар бүлэг. Дотоод ажил:

Хамтын ажиллагаа

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд харилцагч байгууллагуудтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг зохион байгуулах, иргэд, олон нийттэй харилцах, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлууд тусгагдсан ажил 100 хувь биелсэн.

Мөн Дорнод Их сургууль, Политехникийн коллежийн нягтлан бодох бүртгэлийн ангийн оюутнуудад Тэргүүлэх аудитор “Төрийн аудитын байгууллагын зорилго, чиглэл” сэдэвт лекц, Боловсролын байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцож, санхүүгийн тайлангийн аудитын талаар мэдээлэл, арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа.

Ажилтнуудыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, хамт олныг идэвхжүүлэх зорилгоор 7 хоног бүр волейболын спортоор хичээллэх цаг гарган тогтмолжуулснаар аймгийн Төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан шилжин явах цомын спортын тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцож гар бөмбөгийн тэмцээнд I байр эзлэн алтан медалийн эзэд болсон.

Иргэд олон нийттэй харилцах, мэдээлэл солилцох зорилгоор Facebook хуудсанд эхний хагас жилийн байдлаар 18 мэдээлэл байршуулж, иргэд олон нийтээс 1593 хандалт авсан байна. Мөн audit.mn цахим хуудсанд хийсэн аудитуудтай холбоотой мэдээлэл, Шилэн дансны цахим хуудсанд төсөв, санхүүтэй холбоотой мэдээллүүдийг тогтмол байршуулж ажиллалаа.

Сургалт

Тайлант хугацаанд 5 сургалтад давхардсан тоогоор 8 хүн хамрагдсан байна. Үүнд:

1. Ахлах шинжээч Ж.Баяртуул, шинжээч Б.Батжаргал нар Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалтад суун тус бүр 2 хөнгөлөлт авсан.
2. Шинжээч М.Ухаанбилэг ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох /АЗ/ сургалт, шалгалтад амжилттай оролцсон.
3. Дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул, шинжээч Батжаргал нар Инстудийн өөрчлөлт хийх замаар төрийн албыг чадавхжуулах үндсэн зорилготой мерит төслийн төлөвлөлт сэдэвт.
4. Дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул, ахлах аудитор Д.Нармандах нар ҮАГ-аас зохион байгуулсан удирдах ажилтны сургалтад зөвлөгөөнд.
5. Жолооч, нярав П.Золбаяр МНБ-ын аймгийн салбараас зохион байгуулсан няравын сургалтад амжилттай хамрагдан гэрчилгээ авсан.

Өргөдөл гомдол шийдвэрлэлт

Эхний хагас жилийн байдлаар 9 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн хариуг хүргүүлээд байна. Үүнд:

- ✓ Өргөдөл 3.
- ✓ Гомдол 4.
- ✓ Санал хүсэлт 2.

Долоодугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл:

2017 оны 1 дүгээр улирлын Санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Татвар болон нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох журам зааврын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар илэрхийлэн гарган ҮАГ-т хүргүүлээд байна.

Тайлант хугацаанд төсвөөс 90,8 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 85,0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцууллаа.

Төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын тайлан, мэдээг гарган сар бүр аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс болон ҮАГ-ын Ерөнхий санхүүчид, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангуудыг бүрэн үзүүлэлтээр нь гарган тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, цахимаар болон цаасаар гарган холбогдох газруудад хүргүүлж ажилласан.

Газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Улаанбаатар аудит корпораци ХХК –иар баталгаажуулан Зөрчилгүй санал дүгнэлт аваад байна.

Мөн НББ-ийн тухай хуулийн 12.2.5-д заасны дагуу газрын нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Дарга, Тэргүүлэх аудиторов тушаалаар томилогдсон комисс байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хийн элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглагдах боломжгүй 10 нэр төрлийн 15 ширхэг 8079,4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшилыг актлуулах саналыг тамгын газарт хүргүүлсэн.

Наймдугаар бүлэг. Дүгнэлт санал:

1. Аймгийн ИТХ нь Сангийн яамнаас ирүүлсэн 2015 оны орон нутгийн төсвөөр нийт 7 орон тоотой байхаар батлагдсанаас 13 орон тоотой ажиллаж 37,5 сая төгрөгийн цалин, Засаг даргын Тамгын газар нь үндсэн болон гэрээтээр нийт 63 орон тоотой байхаар батлагдсанаас 75 орон тоотой ажиллаж 95,4 сая төгрөгийн цалинг тус тус илүү зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 67 тоот тогтоолын 3 дахь заалт, Сангийн яамны дэд сайдын 2014 оны Орон нутгийн 2015 оны төсөв хүргүүлэх тухай 4-1/6348 албан тоот, 2014 оны “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 тоот тогтоолын 1 дүгээр заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа тул Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 67 тоот

тогтоолын 3 дахь заалт, Сангийн яамны дэд сайдын 2014 оны Орон нутгийн 2015 оны төсөв хүргүүлэх тухай 4-1/6348 албан тоот, 2014 оны “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 тоот тогтоолын 1 дүгээр заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлсэн боловч 2016 онд энэ зөрчил давтагдан гарч байна.

Иймд энэ асуудлыг улсын хэмжээнд нэгтгэн, судалж, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс Санхүү төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад уламжилан, нэгдсэн арга хэмжээ авч өгнө үү.

2. Гүйцэтгэл болон нийцлийн аудитаар хөрөнгө оруулалтын барилга байгууламж, төсөл хөтөлбөрөөр хийгдсэн арга хэмжээг фото зургаар баримтжуулахад мэргэжлийн зургийн аппарат шаардлагатай байгааг анхаарч, мөн автомашин элэгдлээ бүрэн нөхсөн, засвар үйлчилгээ хийх шаардлага байнга тулгарч байна. Иймд амортизатор, нүүрсэн яндан, сэвчээ, холимогийн хаалт, акумлятор солих засвар үйлчилгээний хөлсөд шаардагдах 5,0 төгрөгийг нэмж урсгал засварын зардалд тусгуулах саналтай байна.

3. УАГ-ын хэмжээнд нэгдсэн удирдамжаар хийхээр төлөвлөгдсөн аудитууд орон нутаг дахь байгууллагуудад тухайн сэдвийн хамрах хүрээнээс шалтгаалж харилцан адилгүй хуваарилагддаг.

Санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитууд нь УАГ-т цаг хугацаа, хүн хүчний хувьд тусдаа төлөвлөгдөн гүйцэтгэгддэг ч Дорнод аймаг нь газар зүйн байршил, бүс нутгийн онцлогоос шалтгаалж ихэнх аудитуудын сэдвийн хамрах хүрээнд байдгаас, ажилтнууд нэг цаг хугацаанд 2-оос багагүй аудитыг хавсран болон хамтран гүйцэтгэж байна. Мөн төлөвлөгөөт бус аудитууд ч нэмэгдэж байгаа нь аудитын чанар, хүний нөөцийн зохион байгуулалт, ажлын ачаалалд ч нөлөөлж байна.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

